

Монгол Улсын Засгийн газар COVID-19-ийн халдвар тархахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг эртнээс эрчимтэй авч эхэлсэн. Боловсролын байгууллагуудын үйл ажиллагааг 1-р сарын 27-ноос эхлэн албан ёсоор зогсоож, коронавирусын халдвар илэрсэн улсууд руу зорчих аялалын хориг тавьсан төдийгүй 2-р сарын 13-нд Монгол улс онцгой байдлын өндөржүүлсэн бэлэн байдалд шилжсэн. Мөн 2020 оны 2-р сарын 24-26-ний өдрүүдэд тохиосон Сар шинийн баярын үеэр коронавирусын халдвар гарах болзошгүй байдлаас урьдчилан сэргийлэх зорилгоор Улсын Онцгой Комиссоос хот хоорондын зорчих хөдөлгөөнийг хориглох шийдвэр гаргасан. Нийслэл Улаанбаатар хот хүн амын төвлөрөл ихтэй, Монгол улсын нийт хүн амын тэн хагас нь оршин суудаг. Үүгээр зогсохгүй, Улаанбаатар хотоор дамжин зорчих хөдөлгөөн их тул коронавирусын халдварыг улс даяар тараах эрсдийн хамгийн том хүчин зүйлсийн нэг болж байна. Эрсдийн бэлэн байдлыг цаг ямагт хангаж, коронавирус илэрсэн үед авах арга хэмжээг чанаржуулахын тулд, иргэдийн орж, гарах урсгалын талаарх бүртгэл мэдээллийг сайжруулах ажлыг Нийслэлийн Засаг Даргын Тамгын Газар (НЗДТГ), Олон Улсын Шилжилт Хөдөлгөөний Байгууллага (ОУШХБ)-ын Монгол дахь салбарын техник туслалцаатайгаар хэрэгжүүлж байна. НЗДТГ болон ОУШХБ-ын хамтын ажиллагааны дагуу мэдээлэл цуглуулах ажилд 400 гаруй эмнэлгийн болон боловсролын салбарын ажилтныг дайчлан хамруулж, ДТМ аргачлалд сурган, хэрэгцээт зөвлөмж, техникийн туслалцаагаар ханган ажиллаж байна. Хот хоорондын хөдөлгөөн хязгаарлалттай үед буюу 2-р сарын 27-ны 08 цагаас 3-р сарын 3-ны 06 цаг хүртэл урсгал хөдөлгөөнийг хянах ажлын туршилтын үе хийгдэж, үүнээс хойш 5-р сарын 1-ний өдрийг хүртэл үргэлжилнэ. Нийслэлийн ойролцоох 6 (Эмээлт, Баруунтуруун, Гүнт, Өлзийт, Морин, Налайх) шалган нэвтрүүлэх товчоод дээр тээврийн хэрэгслийн төрөл, зорчигчдын тоо, хүйс, зорчин явж буй чиглэлийн талаарх мэдээллийг 24 цагийн турш иргэдээс авч байна. Хэдийгээр ДТМ аргачлалыг нийслэл хотод анх удаа ашиглаж байгаа боловч дэлхийн 80 гаруй улсад онц байдлын үед ашигладаг ба зөвхөн 2018 онд л гэхэд 40 сая гаруй хүнийг хамруулжээ. Мөн 2018 онд Өмнөд Судан улсад Эбола вирус тархах үеэр иргэдийн хөдөлгөөнийг тандах зорилгоор ДТМ аргачлалыг амжилттай хэрэгжүүлсэн байна. Монгол улсын хувьд Онцгой Байдлын Ерөнхий Газар, ОУШХБ хамтран 2018 оноос хойш 21 аймаг, 330 сумд дахь иргэдийн хөдөлгөөнийг баримжаалан тандаж байгалийн гамшиг, тэр дундаа зудын нөхцөл үүссэн үед ажиллах бэлтгэл ажлыг хангах зорилгоор уг аргачлалыг хэрэглэж ирсэн.

ТОЙМ ТОО

1,635,652

Хөдөлгөөний нэмэгдсэн дүн ДТМ (УХЦ) урсгал хянасан хөдөлгөөний цэгээр хянасан.

63,916

Сүүлийн 24 цагт бүртгэгдсэн хөдөлгөөн

10,196 (X)
43,393 (Ч)

Зорчих хөдөлгөөн хориотой (X) болон чөлөөтэй (Ч) үеийн өдрийн дундаж хөдөлгөөн

ХҮН АМ ЗҮЙ

XX% - Нийт
XX% - Сүүлийн 24 цагт



ЭРЭГТЭЙ

51%
51%



ЭМЭГТЭЙ

31%
32%



ХҮҮ

10%
10%




ОХИН

8%
7%

ХҮНИЙ ХӨДӨЛГӨӨН (НИЙТ)




ХӨДӨЛГӨӨНИЙ ЧИГЛЭЛ



ТОВЧООД ДЭЭРХ ХӨДӨЛГӨӨНИЙ УРСГАЛ


Товчоо	НИЙТ			2020-4-11		
	НИЙТ	Орсон	Гарсан	НИЙТ	Орсон	Гарсан
Баруунтуруун	338,561	161,993	176,568	5,849	2,220	3,629
Өлзийт	248,492	127,878	120,614	9,870	5,371	4,499
Налайх	505,204	253,223	251,981	20,607	10,158	10,449
Морин	346,377	173,326	173,051	37,205	18,556	18,649
Эмээлт	543,769	295,418	248,351	7,812	5,140	2,672
Гүнт	253,380	126,389	126,991	13,928	6,457	7,471
НИЙТ	2,235,783	1,138,227	1,097,556	95,271	47,902	47,369

УЛААНБААТАР РУУ ЧИГЛЭСЭН ХӨДӨЛГӨӨН




Legend

УБ-т очих дүүрэг



Гарсан аймаг



 Улсын хил
 Гол зам

Энэхүү зураглалд ашигласан хил, хязгаар, нэр, нэршил нь албан ёсоор хүлээн зөвшөөрөгдсөнийг илтгэхгүй болно

ХҮН АМ ЗҮЙ

XX% - Нийт

XX% - Сүүлийн 24 цаг



ЭРЭГТЭЙ

51%

52%



ЭМЭГТЭЙ

32%

32%



ХҮҮ

9%

9%



ОХИН



8%

7%

Улаанбаатарт очсон дүүрэг	?	Багахангай	Багануур	Баянгол	Баянзүрх	Чингэлтэй	Хан-Уул	Налайх	Сонгинохайрхан	Сүхбаатар	НИЙТ
Улаанбаатар	2,128	6,116	19,907	36,274	79,177	25,152	171,825	49,983	184,937	24,995	600,494
Архангай	123	12	49	4,717	6,014	1,863	2,943	138	9,201	1,678	26,738
Баянхонгор	57	10	48	1,825	2,749	897	1,364	122	5,010	927	13,009
Баян-Өлгий	10	-	-	202	353	68	86	12	634	144	1,509
Булган	164	22	39	3,808	5,039	1,450	2,609	68	6,283	1,225	20,707
Дархан-Уул	212	34	108	5,619	6,915	1,847	3,956	294	14,295	2,207	35,487
Дорнод	61	17	10	1,070	4,528	656	1,037	49	1,079	815	9,322
Дорноговь	90	15	52	2,726	6,143	799	1,874	134	2,158	1,187	15,178
Дундговь	74	13	19	2,591	5,985	940	3,147	48	3,173	1,370	17,360
Говь-Алтай	23	11	31	703	1,328	332	586	27	2,304	365	5,710
Говьсүмбэр	56	9	48	1,807	5,983	575	1,214	118	1,179	913	11,902
Хэнтий	91	6	20	2,272	12,968	1,277	2,109	142	2,240	1,814	22,939
Ховд	7	-	12	637	1,199	283	656	40	2,342	184	5,360
Хөвсгөл	65	25	78	2,537	3,345	837	1,710	74	4,886	972	14,529
Орхон	110	4	89	4,679	5,521	1,277	3,505	174	7,391	1,773	24,523
Сэлэнгэ	131	34	147	7,675	8,209	2,467	4,152	314	9,268	2,560	34,957
Сүхбаатар	56	14	23	690	4,319	385	613	59	669	573	7,401
Төв	929	166	528	30,564	42,725	13,790	34,827	2,896	57,387	14,669	198,481
Өмнөговь	112	5	43	3,244	5,935	1,112	5,720	96	5,639	1,502	23,408
Өвөрхангай	137	51	78	4,756	6,398	1,894	4,111	171	11,634	1,735	30,965
Завхан	52	10	13	1,518	2,560	558	1,103	57	3,046	771	9,688
Увс	18	5	18	739	1,554	343	626	89	2,450	329	6,171
?	46	8	19	336	724	102	354	184	565	199	2,537
НИЙТ	4,752	6,587	21,379	120,989	219,671	58,904	250,127	55,289	337,770	62,907	1,138,375




УЛААНБААТАРААС ГАРСАН ХӨДӨЛГӨӨН



Энэхүү зураглалд ашигласан хил, хязгаар, нэр, нэршил нь албан ёсоор хүлээн зөвшөөрөгдсөнийг илтгэхгүй болно

ХҮН АМ ЗҮЙ

XX% - Нийт
XX% - Сүүлийн 24 цаг



Улаанбаатараас гарсан дүүрэг	?	Багахангай	Баянзүрх	Багануур	Баянгол	Чингэлтэй	Хан-Уул	Налайх	Сонгинохайрхан	Сүхбаатар	НИЙТ
Арханагай	302	15	4,506	36	3,388	1,507	2,278	143	8,025	1,322	21,522
Баянхонгор	86	18	1,745	78	1,375	650	1,134	62	4,390	620	10,158
Баян-Өлгий	-	-	342	-	225	51	84	4	529	87	1,322
Булган	203	1	3,998	31	3,060	1,379	2,179	34	6,010	1,072	17,967
Дархан-Уул	115	13	5,833	88	4,780	1,729	3,539	223	16,723	1,951	34,994
Дорнод	63	8	4,912	2	902	632	1,042	52	957	678	9,248
Дорноговь	69	5	7,088	81	2,824	1,054	2,241	108	2,249	1,135	16,854
Дундговь	74	17	5,819	70	2,239	1,005	3,195	68	3,504	1,356	17,347
Говь-Алтай	31	9	856	18	353	225	458	49	2,102	221	4,322
Говьсүмбэр	50	-	5,709	35	1,495	582	999	85	1,148	679	10,782
Хэнтий	111	8	12,565	22	2,131	1,122	1,744	109	1,876	1,588	21,276
Ховд	13	-	837	7	434	141	438	38	1,858	205	3,971
Хөвсгөл	62	3	2,231	16	1,370	604	1,291	54	4,533	610	10,774
Орхон	117	9	4,430	92	4,051	1,257	2,953	138	8,092	1,328	22,467
Сэлэнгэ	69	17	7,062	145	7,051	2,156	3,875	396	9,962	2,203	32,936
Сүхбаатар	36	6	4,413	6	524	387	671	26	780	665	7,514
Төв	1,102	117	41,254	548	28,584	13,085	32,765	2,641	56,973	13,871	190,940
Өмнөговь	72	20	6,765	91	3,511	1,445	6,063	119	6,181	1,972	26,239
Увс	26	7	788	18	350	214	367	31	1,545	198	3,544
Өвөрхангай	208	24	4,650	67	3,575	1,242	3,128	83	9,883	1,363	24,223
Завхан	70	11	1,442	17	828	381	682	66	2,529	361	6,387
?	123	10	601	46	256	133	250	256	652	163	2,490
НИЙТ	3,002	318	127,846	1,514	73,306	30,981	71,376	4,785	150,501	33,648	497,277